

**“ОРОН НУТГИЙН САЛБАР ХООРОНДЫН БОДЛОГЫН ЗОХИЦУУЛАЛТ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Орон нутгийн салбар хоорондын бодлогын зохицуулалт”
- ✓ **Зорилго:** Бодлогын зохицуулалтын талаар цэгцтэй ойлголт эзэмшүүлж, үндэсний болон салбарын бодлогыг орон нутгийн түвшинд уялдуулан төлөвлөх арга зүйд суралцана.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Бодлогын зохицуулалтын талаарх үндсэн ойлголт; Урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан үндэсний болон салбарын үр дүн, тэдгээрийн уялдаа; Үндэсний болон салбарын түвшинд тодорхойлсон бодлогыг орон нутгийн түвшинд уялдуулан төлөвлөх арга зүй

Сэдэв 1. Бодлогын зохицуулалтын талаарх үндсэн ойлголт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Бодлогын зохицуулалтын үндсэн ухагдахуун, түүнийг нутгийн удирдлагад хэрэгжүүлэх боломж нөхцлийн талаар тайлбарлана.

Сэдэв 2. Урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан үндэсний болон салбарын үр дүн, тэдгээрийн уялдаа

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан үндэсний, салбарын үр дүнгийн харилцан уялдааг тайлбарлана.

Сэдэв 3. Үндэсний болон салбарын бодлогыг орон нутгийн түвшинд, бүс, орон нутгийн онцлогт нийцүүлэн уялдуулан төлөвлөх аргачлал

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага/кейс дасгал

Сэдвийн агуулга: Улсын хөгжлийн бодлогын үр дүнг орон нутгийн хөгжлийн төлөвлөлт болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх талаар цэгцтэй ойлголт, хэрэглэх ур чадварт суралцана.

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага/кейс, жишээ
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Энэхүү хичээлийг үзэхээс өмнө дараах хичээлүүдийг сонгон судлах нь оновчтой. Үүнд:
 - Монгол Улсын төрийн бодлого, түүхэн уламжлал
 - Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлтЭнэхүү хичээлийг үзсэний дараагаар дараах хичээлүүдээс сонгон судлах нь оновчтой. Үүнд:
 - Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага
 - Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй
 - Орон нутгийн бодлогын үнэлгээ хийх арга зүй”

“ОРОН НУТГИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Орон нутгийн стратеги төлөвлөлт
- ✓ **Хичээлийн зорилго:** Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдсан стратегийн төлөвлөлт хийх мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын ажлын албаны ажилтнууд
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Орон нутгийн стратеги төлөвлөлт, түүний онцлог

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц/ярилцлага

Сэдвийн агуулга: Стратегийн үндсэн ойлголт, төрийн салбар дахь стратегийн төлөвлөлт, түүний онцлог, туршлага ба сургамж, эрх зүйн шинэтгэл, стратегийн төлөвлөгөө боловсруулах үйл явц

Сэдэв 2. Нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн стратеги тодорхойлох

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц/ярилцлага, дасгал ажил

Сэдвийн агуулга: Агуулга. Орон нутгийн нөхцөл байдлыг тодорхойлох, шинжилгээ хийх (жиш: боломж ба эрсдэл, давуу ба сул тал), шинжилгээний үр дүнд тулгуурлан стратеги тодорхойлох (жиш: аймгийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулах)

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Энэ хичээлийн хөтөлбөр нь бататгах түвшний сургалтад зориулагдсан болно.
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, харилцан ярилцах, багаар ажиллах. Уг сэдвийн хүрээнд хичээлийн ерөнхий агуулгыг суралцагчдад хүргэхдээ лекц, харилцан ярилцах хэлбэрээр, мөн хичээлийн ойлголтыг бататгах зорилгоор дасгал ажиллах үйл ажиллагааг зохион байгуулна.
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хичээлийн хөтөлбөрийн судлахын өмнө суурь түвшний сургалтыг дүүргэсэн байна. Тухайлбал, Орон нутгийн бодлого боловсруулалт, ИТХ-ын чиг үүрэг, үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явцтай холбоотой хичээлийг судалсан байна.

**“ӨГӨГДӨЛ МЭДЭЭЛЛИЙГ ОРОН НУТГИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД АШИГЛАХ АРГА ЗҮЙ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** “Өгөгдөл мэдээллийг орон нутгийн төлөвлөлтөд ашиглах арга зүй”
- ✓ **Зорилго:** Орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх үйл явц, тавигдаж буй шаардлагын хүрээнд өгөгдөл мэдээллийг баримт нотолгоотойгоор бүрдүүлэх, шаардлагатай дүн шинжилгээ хийх ур чадварыг эзэмшүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид, Хурлын ажлын албаны албан хаагчид.
- ✓ **Агуулга:** ИТХ-ын орон нутгийн хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөхөд шаарлагатай өгөгдөл мэдээллийг бүрдүүлэх, шинжилгээ хийх арга зүйн талаарх суурь ойлголт эзэмшүүлнэ.

Сэдэв 1. Нотолгоонд суурилсан бодлого болон шийдвэр гаргалт талаарх ойлголт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Нотолгоонд суурилсан бодлого болон шийдвэр гаргалтын талаарх суурь ойлголт, орон нутагт бэлэн байгаа мэдээллийн төрөл, хэлбэр, бэлтгэн нийлүүлэгчид, түүнийг ИТХ авч ашиглах боломж нөхцөл

Сэдэв 2. Орон нутгийн бодлого төлөвлөлтөд баримт нотолгоо, өгөгдөл мэдээллийг ашиглах арга зүй

Ногдох цаг: 6 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага, кейс дасгал

Сэдвийн агуулга: Орон нутгийн бодлого боловсруулах, төлөвлөх болон хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаанд баримт нотолгоо, өгөгдөл мэдээллийг ашиглах болон дүн шинжилгээ хийх мэдлэг ур чадвар эзэмшүүлнэ.

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага/Кейс, дасгал
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:**

Энэхүү сургалтын өмнө нь судлах хөтөлбөрүүд:

- Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт
- Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй I

Дараа нь судлах хөтөлбөрүүд:

- Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй II
- Орон нутгийн бодлогын үнэлгээ хийх арга зүй

“ИТХ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА: ЗӨВЛӨЛ, ХОРОО, АЖЛЫН ХЭСЭГ, ХУРАЛДААН, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хичээлийн нэр:** ИТХ-ын үйл ажиллагаа: зөвлөл, хороо, ажлын хэсэг, хуралдаан, зохион байгуулалт
- ✓ **Хичээлийн зорилго:** ИТХ-ын чиг үүрэг, түүний онцлог, ИТХ-ын эрх зүйн зохицуулалт болон тэдгээрийг хурлын үйл ажиллагаанд оновчтой ашиглах мэдлэг чадвар эзэмшүүлэх
- ✓ **Зорилготой бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын чиг үүрэг, бүтэц

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын чиг үүрэг, түүний онцлог болон ИТХ-ын бүтэц болох хороо (түр хороо, дэд хороо), зөвлөл, ажлын хэсэг, ажлын албаны үүрэг, ИТХ-ын чиг үүрэг, бүтцийн уялдаа, эрх зүйн зохицуулалтын талаар хамруулан авч үзнэ.

Сэдэв 2: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалт

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: ИТХ-д тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, өргөн мэдүүлэх, хуралдаан, хуралдааны бэлтгэл хангах, хуралдааны дэг, хуралдааныг зохион байгуулах зэрэг асуудлуудыг хамруулан авч үзнэ.

- ✓ **Сургалтын цаг: Танхимын нийт 8 цаг**
- ✓ **Сургалтын түвшин:** Энэ хичээлийн хөтөлбөр нь бататгах түвшний сургалтад зориулагдсан.
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, харилцан ярилцах, дасгал ажиллах
Лекц: Сэдвийн хүрээнд хичээлийн ерөнхий агуулгыг суралцагчдад хүргэхдээ лекцийн зарчмаар зохион байгуулах бөгөөд сэдэв тус бүрийн хүрээнд багш кейс, жишээгээр баяжуулан хүргэнэ.
Дасгал ажил: Багаар дасгал буюу кейс ажиллах, түүнийг үр дүнгийн талаар ярилцах, хэлэлцүүлэг өрнүүлэх /асуулт, хариулт/
Багшийн өгсөн удирдамжийн дагуу багаар дасгал ажиллах. Дасгал нь зөвшилцөх, анализ хийх, дүгнэх ур чадварт чиглэсэн байх

✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:**

Уг хичээлийн хөтөлбөрийг судлахын өмнө суурь түвшний “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа”, “Албан бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах арга зүй” хөтөлбөрийг судалсан байна. Харин уг хичээлийн хөтөлбөрийн судласны дараа суурь түвшний “ИТХ-ын төлөөлөгчийн ёс зүй” сургалт болон бататгах түвшний сургалтын “ИТХ-ын шийдвэр, шийдвэр гаргах үйл явц” сургалтыг уялдуулан судлах нь зүйтэй.

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, шийдвэр гаргах үйл явц
- ✓ **Зорилго:** Хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд ИТХ-аас гаргах шийдвэр, шийдвэр гаргах үйл явцын талаар цэгцтэй мэдээлэл өгөх, чанартай шийдвэр гаргах арга зүйд суралцана.
- ✓ **Зорилтот бүлэг:** Шинэ сонгогдсон төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Ерөнхий болон дэд сэдэв бүрийн товч тодорхойлолт, агуулга, ноогдох цаг, заах хэлбэр

Сэдэв 1. Шийдвэр, түүний онцлог

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: ИТХ-аас гаргах шийдвэр /эрх зүйн акт-тогтоол/, түүний үйл явц, шийдвэрийн төслийг боловсруулах талаар ярилцана.

Сэдэв 2. Шийдвэр гаргах үйл явц

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Кейс, багийн ажиллагаа

Сэдвийн агуулга: ИТХ-ын шийдвэрийн төслийг боловсруулахад Засаг даргын оролцоо, шийдвэрийг ёсчлох, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах зэрэг асуудлуудыг хамруулан авч үзнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, ярилцлага, багаар ажиллах кейс дасгал

Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо: Тухайн хөтөлбөрийг судлахын өмнө “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа”, “Албан бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах арга зүй” сургалтуудыг заавал судалсан байх шаардлагатай. Харин сургалтыг судалсны дараа “ИТХ-ын үйл ажиллагаа: Зөвлөл, хороо, ажлын хэсэг, хуралдаан, зохион байгуулалт”, “Орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах” сургалтыг уялдуулан судлах боломжтой.

**“БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, ГАЗРЫН ХАРИЛЦААНД ИТХ болон ИРГЭДИЙН
ОРОЛЦОО” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Байгаль хамгаалал, газрын харилцаанд ИТХ болон иргэдийн оролцоо
- ✓ **Зорилго:** Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-аас нутаг дэвсгэрийнхээ байгаль орчин, газрын харилцааны талаарх шийдвэр гаргахад иргэдийн саналыг авах, хэрэгжилтэд оролцуулах арга барил эзэмшүүлж, дадлагажуулахад чиглэнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, байгаль орчны багц хуулиуд, газрын харилцааны багц хууль, тогтоомжийн хүрээнд нутаг дэвсгэрийн газар, байгаль хамгаалалтай холбоотой асуудлыг тодорхойлох, хамтран шийдвэрлэх, хэрэгжилтэд талуудыг жигд оролцуулах зэрэг арга, аргачлал.

Сэдэв 1. Тогтвортой хөгжил, ногоон хөгжилд улс, орон нутгийн чиг үүрэг, оролцоо

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдэв 2. Байгаль орчин болон Газрын тухай хууль тогтоомжийн хэрэглээ, тулгамдсан асуудал, шийдэл

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага, дасгал

Сэдэв 3. Байгаль орчны элэгдэл, эвдрэл, бохирдолд хүний оролцоо, нөлөө, түүнийг бууруулах арга зам

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдэв 4. Тусгай хамгаалалттай газар нутаг: төр, иргэдийн оролцоо

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага, дасгал

Сэдэв 5. Газар ашиглах, эзэмших, өмчлөх харилцаанд үүссэн асуудал, шийдэл, туршлага, сургамж

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага, дасгал

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг, /Онлайн 4 цаг Оффлайн 4 цаг/
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц-чиглүүлэг, бичил судалгаа, хэлэлцүүлэг, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Тус хичээл нь бататгах түвшний “Та-бодлого тодорхойлогч” модуль бөгөөд “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”, “Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага”, “Хууль тогтоомжийн хэрэглээ”, “ИТХ-ын хуралдаан, шийдвэр гаргах үйл явц”, “Бэлчээрийн менежмент, арга туршлагаууд”, “Засаглал-иргэдийн оролцоо” зэрэг хөтөлбөрүүдтэй уялдана.

**“ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ
- ✓ **Зорилго:** ИТХ-аас батласан орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө болон ИТХ-аас гаргасан шийдвэрүүдэд үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй мэдлэг чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид болон ажлын албаны ажилтнууд
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний онцлог, хэрэглээ

Ногдох цаг: 3 цаг

Хэлбэр: Багшийн лекц, дасгал, кейс

Сэдвийн агуулга: Үр дүнд суурилсан ХШҮ-ний онцлог, ач холбогдол, шийдвэр гаргалтанд ХШҮ-ний мэдээллийг ашиглах нь

Сэдэв 2. Үр дүнд шинжилгээ хийх арга зүй

Ногдох цаг: 5 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Үр дүнгийн төлөвлөгөө нь үр дүнд суурилсан ХШҮ хийх үндэс болох нь, өөрчлөлтийн онол, ХШҮ хийх арга зүй, ХШҮ-ний мэргэжилтэнд тавигдах шаардлага

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, дасгал, кейс, хэлэлцүүлэг
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Энэхүү хичээлийг судлахын өмнө та бодлого тодорхойлогч хэмээх тодотгол бүхий суурь болон бататгах түвшний хичээлүүдийг судалсан байна.

“ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН МЕНЕЖМЕНТ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Өргөдөл гомдлын менежмент
- ✓ **Сургалтын зорилго:** Байгууллагын өргөдөл гомдлын менежментийг актив болгож өөрчлөхтэй холбогдсон онол арга зүйн мэдлэг чадварыг олгоход чиглэгдэнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид болон ажлын албаны ажилтнуудад
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Гомдлыг боломж гэж харахын учир

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Өргөдөл, гомдлын менежментийг сайжруулах хэрэгцээ шаардлага, иргэдийн гомдол гаргах үндэслэл, өргөдөл гомдлын менежментийг сайжруулах эхний алхам нь гомдлыг боломж гэж харах сэтгэлгээний өөрчлөлтөөс эхлэх нь.

Сэдэв 2. Өргөдөл гомдлын актив менежментийг хэрэгжүүлэх нь

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Багшийн лекц, кейс, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Иргэдийн гомдлоо илэрхийлэх эсэх нь тухайн байгууллагын өргөдөл, гомдлын менежментээс хамаарах нь, пассив менежментийг актив болгон өөрчлөх нь, өргөдөл гомдлын актив менежментийн үйл явц, иргэдийн өргөдөл гомдлоор ирүүлсэн мэдээлэл ажил сайжруулах үндэс болох нь.

- ✓ **Сургалтын цаг:** Танхимын 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, хэлэлцүүлэг, кейс, дасгал
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хичээлийг судлахын өмнө суурь түвшний сургалтыг дүүргэсэн байна.

**“АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ЗҮЙ”
ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР**

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Ажлын гүйцэтгэлийг тайлагнах арга зүй
- ✓ **Зорилго:** Ажлын гүйцэтгэлийн үр дүнг тодорхойлох, түүнийг тайлагнах арга зүйтэй холбогдох мэдлэг чадварыг олгоход чиглэгдэнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид
- ✓ **Агуулга:**
 - Сэдэв 1. Ажлын гүйцэтгэлийн үр дүн, түүнийг хэмжих нь**
 - Ногдох цаг: 4 цаг
 - Хэлбэр: Лекц, дасгал, кейс, хэлэлцүүлэг
 - Сэдвийн агуулга:** Монгол Улсын төрийн салбар дахь гүйцэтгэлийн удирдлагын хөгжил, төлөөлөгчийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг хэмжих хэрэгцээ шаардлага, үр дүнг хэмжих үзүүлэлт, түүнийг төлөвлөх, тайлагнах, хянахад ашиглах нь.
 - Сэдэв 2. Ажлын гүйцэтгэлийн үр дүнг тайлагнах арга зүй**
 - Ногдох цаг: 4 цаг
 - Хэлбэр: Лекц, дасгал, кейс
 - Сэдвийн агуулга:** Гүйцэтгэлийн үр дүнгийн тайлан, түүний зориулалт болон зорилтот хэрэглэгч, тайланд тавигдах шаардлага, тайлангийн бүтэц, тайлагнах арга хэлбэр, гүйцэтгэлийн тайланг ХШҮ-д ашиглах нь
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, хэлэлцүүлэг, багаар ажиллах кейс дасгал
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хичээлийн хөтөлбөрийн судлахын өмнө суурь түвшний сургалтыг дүүргэсэн байна.

“ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Төсөл боловсруулах арга зүй
- ✓ **Зорилго:** ИТХ-ын байгууллага, төлөөлөгчдийн орон нутагт чиг үүргээ хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд шаардлагатай төслийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар, цэгцтэй мэдлэгийг системтэй эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, нарийн бичгийн дарга, хурлын ажлын албаны албан хаагчдад
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Төслийн тухай ойлголт:

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Орон нутгийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай төсөл боловсруулах, удирдах онол арга зүйн хүрээнд холбогдох ойлголтуудыг өгнө. Үүнд: Төсөл болон төслийн удирдлагын ялгааны тухай, Төсөл гэж юу вэ? Төслийн удирдлага гэж юу вэ? Төслийн олон улсын стандартын талаар академик 2 цаг буюу 1.30 минутад лекцийн аргаар сургалтыг зохион байгуулна.

Сэдэв 2. Төсөл боловсруулах арга зүй:

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Төслийн баримт бичиг боловсруулах болон төслийн үйл ажиллагааг иж бүрэн төлөвлөх арга зүйг лекц, танин мэдэхүйн аргаар зохион байгуулна. Тус агуулгын хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн загвар төслийг жишээ болгоно.

Сэдэв 3. Төслийн удирдлагын арга зүй:

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Төслийн нөхцөл байдлын шинжилгээнд тулгуурлан амьдралын мөчлөг, графикчигсан төлөвлөгөө боловсруулах арга зүйг орон нутгийн жишээгээр идэвхтэй оролцооны аргад тулгуурлан багаар ажиллах аргаар зохион байгуулна.

Сэдэв 4. Төслийн олон улсын стандарт.

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Төслийн 5 хэмжээс, 5 үе шат, 10 менежмент, 39 алхамаар хэмжих, үнэлэх, хянах арга зүйг багаар ажиллах, танин мэдэхүйн аргаар зохион байгуулна.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах. Орон нутагт хэрэгжүүлэх төсөл боловсруулах системтэй ойлголтын талаар шинэ мэдээлэл өгөх, өмнөх сургалтаар эзэмшсэн мэдлэг чадвараа бататгах, эргэн санах, баяжуулах зорилготой.
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, семинар, ярилцлага, кейс дасгал ажиллах, багаар ажиллах, танин мэдэхүйн болон идэвхтэй оролцооны аргад тулгуурлан зохион байгуулна.
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Тус хичээлийн өмнөх шатанд Орон нутгийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй, Орон нутгийн эдийн засгийн төлөвлөлт, Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага, Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, Орон нутгийн бодлогын шинжилгээ хийх арга зүй чиглэлээр зохих мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна.

Цаашид Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг хянах арга зүй, Ажлын гүйцэтгэлийг тайлагнах арга зүй, Өгөгдөл мэдээллийг орон нутгийн төлөвлөлтөд ашиглах арга зүй зэрэг агуулга бүхий хичээлүүдийг гүнзгийрүүлэн үзнэ.

“ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Харилцааны ур чадвар
- ✓ **Зорилго:** Өөрийгөө болон бусдыг таних мэдэж, харилцан ойлголцож, хүлээн зөвшөөрч, нөлөөлөх арга зүйд суралцаж, харилцааны ур чадваруудаа дээшлүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Өөрийгөө ялж, амжилтанд тэмүүлэхийн тулд хувь хүний манлайллын нөлөөллийн хүрээнд бусдыг танин мэдэж, тэдэнтэй харилцан ойлголцох, нөлөөлөх арга зүйд суралцах замаар харилцааны ярих, сонсох, бичих, унших чадваруудаа хөгжүүлнэ.

Сэдэв 1. Өөрийгөө бусдад зөв илэрхийлж хүлээн зөвшөөрүүлэх

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, ярилцлага, сорил

Сэдвийн агуулга: Өөрийгөө танин мэдэж зөв илэрхийлэх, ялах, улмаар өөрийгөө болон бусдыг өдөөн сэдэлжүүлж харилцаа дээр суурилан амжилтанд тэмүүлэх, хувь хүний манлайллын нөлөөг дэвшүүлэн бусдад нөлөөлөх талаар арга зүй, тактикийг эзэмшиж болох тухай тайлбарлан ойлгуулж, сорил ажиллаж, бусдын түүхээс суралцаж болох талаар багш зөвлөнө.

Сэдэв 2. Бусдыг ойлгох, бие биенээ таньж мэдэж, хүлээн зөвшөөрөх

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Хүйсийн болон хувь хүн, бие хүний сэтгэл зүйн онцлог, төлөвшлийг мэдэж, бусдад хүндэтгэлтэй хандаж, хүлээн зөвшөөрч, тэдэнтэй нийцэж, нөлөөлөх талаар ойлголтоо бататган, өнөөгийн монгол хүний үнэт зүйл, хандлага, сэтгэлгээний талаар ярилцана. Үнэлэлт, дүгнэлт гаргаж хэлэлцэнэ.

Сэдэв 3. Харилцааны чадваруудыг хөгжүүлэх

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Багийн ажил, ярилцлага, хэлэлцүүлэг

Сэдвийн агуулга: Харилцааны ярих, сонсох, бичих, унших чадвар тус бүр дээр багаар ажиллаж, тухайн чадвар өнөөгийн байдлаар бид бүхэнд ямар байгаа, яаж сайжруулах, үүний тулд юуг мэдэж, сурч, хөгжих талаар ярилцана. Багш эдгээр чадваруудыг сайжруулах арга замыг хэлэлцүүлнэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, хэлэлцүүлэг, ярилцлага, сорил, дасгал, багаар ажиллах,
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хөтөлбөр нь бататгах түвшний “Та-зөвлөн туслагч” модуль бөгөөд “ИТХ-ын ёс зүй”, “Засаглал-иргэдийн оролцоо”, “Олон нийтийн харилцаа” “Гадаад харилцаа, дипломат ёс” зэрэг сургалтын хөтөлбөрүүдтэй уялдана.

“НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГА” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Нийгмийн эгэх хариуцлага
- ✓ **Зорилго:** Нийгмийн эгэх хариуцлагын тухай ойлголт, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх тухай онолын болон арга зүйн мэдлэг, чадвар эзэмшинэ.
- ✓ **Зорилгот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Нийгмийн эгэх хариуцлагын тухай ойлголт, төрийн санхүүгийн удирдлагын ойлголт, төрийн санхүүгийн удирдлагын цикл болох төлөвлөлт, төсөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн үе шатанд нийгмийн эгэх хариуцлагыг хэрхэн хэрэгжүүлэх тухай арга зүйн мэдлэг эзэмшинэ.

Сэдэв 1. Нийгмийн эгэх хариуцлагын тухай ойлголт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Нийгмийн эгэх хариуцлага үүсэх хэрэгцээ шаардлага, үндсэн ойлголт, нийгмийн эгэх хариуцлага сайн засаглалыг бэхжүүлэх арга болох тухай мэдлэг эзэмшинэ.

Сэдэв 2. Монгол улсын төрийн санхүүгийн удирдлагын орчил

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Багшийн лекц, дасгал

Сэдвийн агуулга: Төрийн санхүүгийн удирдлагын тухай ойлголт, түүний дөрвөн цикл болох төлөвлөлт, төсөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн үнэлгээний үе шатын талаар онолын мэдлэг эзэмшинэ.

Сэдэв 3. Нийгмийн эгэх хариуцлагын арга

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Багшийн лекц, дасгал

Сэдвийн агуулга: Төлөвлөлтийн үе шат (оролцоот төлөвлөлт, оролцоот бодлого боловсруулалт), төсөвлөлтийн үе шат (оролцоот төлөвлөлт, төсвийн хараат бус шинжилгээ), зарцуулалтын үе шат (худалдан авах ажиллагааны хяналт), гүйцэтгэлийн үе шатанд (хэрэглэгчийн үнэлгээний карт, иргэдийн онооны картын) нийгмийн эгэх хариуцлагыг хэрхэн хэрэгжүүлэх тухай мэдлэг эзэмшинэ.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, харилцан ярилцах, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хичээлийн хөтөлбөр нь бататгах түвшний сургалт бөгөөд суурь түвшний “Монгол Улсын улс төрийн бодлого, түүхэн уламжлал”, “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт” “Засаглал-иргэдийн оролцоо” зэрэг хөтөлбөрүүдтэй уялдана.

“ОЛОН НИЙГИЙН ХАРИЛЦАА” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Олон нийтийн харилцаа
- ✓ **Зорилго:** Олон нийтийн харилцааны тухай онол, арга зүйн мэдлэгийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын олон нийттэй харилцах ажлын төлөвлөлт, хэрэгжилт, баримтлах зарчмыг ойлгож, олон нийттэй харилцах ажлыг үр дүнтэй удирдан зохион байгуулах чадварыг дээшлүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын залуу төлөөлөгчид, хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**
 - Сэдэв 1. Олон нийтийн харилцааны тухай үндсэн ойлголт, онол загвар, баримтлах зарчим**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдэв 2. Олон нийтийн санаа бодлыг судлах, үр дүнг хэрэглэх нь**
 - Ногдох цаг: 3 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдэв 3. Олон нийттэй харилцах ажлын төлөвлөлт, хэрэгжилт**
 - Ногдох цаг: 3 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц: Онол, арга зүйн мэдээлэл, Семинар: Багийн ажил, хэлэлцүүлэг, кейс дасгал, танилцуулга
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Бусад хөтөлбөртэй агуулгаас үл хамааран ойлголт, арга зүйн хувьд уялдана.

“ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Төр, хувийн хэвшлийн түншлэл
- ✓ **Хичээлийн зорилго:** Суралцагчдад төр, хувийн хэвшлийн түншлэл тухай ойлголт, үндсэн асуудал, төрөл, хэлбэрүүд, хэрэгжүүлэх боломж, арга зам, санхүүжилт, олон улсад хэрэгжүүлж буй туршлага, зардал, үр ашгийг тооцох арга зүйг эзэмшүүлнэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын ажлын албаны ажилтнууд
- ✓ **Агуулга:**
 - Сэдэв 1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай ойлголт, үндсэн асуудал, төр, хувийн хэвшлийн түншлэлийн төрөл, хэлбэрүүд**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдэв 2. Төслийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, гэрээ байгуулах үйл явц**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдэв 3. Нийгмийн суурь үйлчилгээ болон дэд бүтцийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх нь**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдэв 4. Байгаль орчны салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэрэгжилт, онцлог**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, харилцан ярилцах, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хөтөлбөр нь бататгах түвшний “Та-зөвлөн туслагч” модуль бөгөөд “Орон нутгийн салбар хоорондын бодлого зохицуулалт”, “Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага” хөтөлбөртэй уялдана.

“ГЭРЭЭНИЙ УДИРДЛАГА” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Гэрээний удирдлага
- ✓ **Зорилго:** Орон нутгийн төсөв, орон нутгийн өмчийн эрхийг гэрээний эрх зүйн зохицуулалтаар хамгаалах, гэрээг зөв хэрэглэх, гэрээгээр дамжуулан шийдвэр гаргалтыг оновчтой болгох арга зүй эзэмшүүлэх.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**
 - Сэдэв 1. Гэрээг эрсдлээс хамгаалах хууль зүйн арга болгож хэрэглэх талаар ойлголт өгөх**
 - Ногдох цаг: 4 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдэв 2. Гэрээнд тавигдах хууль зүйн шаардлага, гэрээ байгуулахад эдгээрийг анхаарах нь**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
 - Сэдэв 3. Орон нутгийн төсөвт учруулсан хохирлыг барагдуулах эрх зүйн орчин**
 - Ногдох цаг: 2 цаг
 - Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал
- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах түвшин
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Ойлголт өгөх, Дадлагын хичээл
 - Гэрээний загвар дээр шинжилгээ хийх, ярилцлага
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хөтөлбөр нь бататгах түвшиний “Та-зөвлөн туслагч” модульд багтах бөгөөд “Орон нутгийн төсөв: төлөвлөх, батлах, хяналт тавих”, “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн үндэс, үйл ажиллагаа”, “Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг хянах арга зүй”, “Орон нутгийн салбар хоорондын бодлогын зохицуулалт”, “Хууль тогтоомжийн хэрэглээ” зэрэг хөтөлбөрүүдтэй уялдана.

“ӨӨРЧЛӨЛТИЙН УДИРДЛАГА” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Өөрчлөлтийн удирдлага
- ✓ **Зорилго:** Өөрчлөлт шинэчлэлийг нөхцөл байдлын өрнөлөөс хамаарч яаж бүтээлчээр хэрэгжүүлж, зохион байгуулах талаар цэгцтэй мэдлэг ойлголт олгоно.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:** Өөрчлөлт шинэчлэлийн удирдлагын үйл явц, түүний үндсэн чиглэлүүд, өөрчлөлтөд хүмүүсийн зүгээс гарах хандлагууд, өөрчлөлтийг үр дүнтэй удирдах болон манлайлах нь

Сэдэв 1. Өөрчлөлтийн хэрэгцээ, хандлага

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Өөрчлөлт шинэчлэлт зайлшгүй болох нь, өөрчлөлтийн үндсэн чиглэлүүд: технологийн, хүний хөгжлийн, бүтэц зохион байгуулалтын, зорилго стратегийн

Сэдэв 2. Өөрчлөлтийн үеийн манлайлагч

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Өөрчлөлтийг үр дүнтэй удирдах арга хэрэгслүүд, оролцогч талуудын хандлагыг зохицуулах, энэ үйл явцад тэднийг татан оролцуулах арга зам

Сэдэв 3. Өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлс

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Гадаад ерөнхий орчин ба зах зээлийн орчны хүчин зүйлүүд, дотоод орчны бүрэлдэхүүн хэсгүүд / судалгаа хөгжил, бүтэц зохион байгуулалт, зохицуулалт, үндсэн үйл ажиллагаа үйлчилгээ, дотоод хяналт үнэлгээ, албан хаагчдын чадавхи

Сэдэв 4. Өөрчлөлтийн үйл явц

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдвийн агуулга: Өөрчлөлтийн үндсэн үе шатууд, гэсгээх өөрчлөн зохион байгуулах, хөлдөөх, Күрт Левний загвар, өөрчлөлтийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг, түүний хэрэгжилтыг хангах үе шатууд

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, харилцан ярилцах, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хөтөлбөр нь “Та-зөвлөн туслагч” модуль бөгөөд “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”, “Орон нутгийн стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “ИТХ-ын төлөөлөгчийн манлайлал” хөтөлбөрүүдтэй уялдана.

“ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт
- ✓ **Зорилго:** Жендэрийн мэдрэмжтэй төсөв зохиох мэдлэг чадвар эзэмшүүлэх
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын дарга, төлөөлөгчид, хурлын нарийн бичгийн дарга, ИТХ-ын хороод болон хурлын ажлын албаны албан хаагчид
- ✓ **Агуулга:**

Сэдэв 1. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт: үндсэн ойлголт, зорилго, үйл явц

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 2. Төсвийн бүтэц, төсөвлөлтийн үйл явц ба жендэр

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 3. Төсвийн жендэрийн шинжилгээ

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 4. Жендэрийн мэдрэмжтэй төсвийн хэрэгжилт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

Сэдэв 5. Төсвийн хэрэгжилтэд хяналт тавих ба жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хөгжүүлэх нь

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Багшийн лекц, хэлэлцүүлэг, дасгал

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Бататгах
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, харилцан ярилцах, дасгал ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:** Уг хөтөлбөр нь бататгах түвшний “Та-зөвлөн туслагч” модуль бөгөөд “Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт”, “Орон нутгийн салбар хоорондын бодлого зохицуулалт”, “Засаглал-иргэдийн оролцоо”, “Орон нутгийн төсөв, төлөвлөх, гүйцэтгэлийг хянах арга зүй” зэрэг хөтөлбөрүүдтэй уялдана.

“ЖЕНДЭРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУСГАХ АРГА БАРИЛ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ **Хөтөлбөрийн нэр:** Жендэрийн үзэл баримтлалыг бодлого, үйл ажиллагаанд тусгах арга барил
- ✓ **Зорилго:** Жендэрийн тэгш байдлыг хангах цогц стратегийн дагуу бодлого төлөвлөх, төсөвлөх, төсвийн зарцуулалт, ХШҮ-г хийхдээ жендэрийн мэдрэмжтэй хандах онол, арга зүйн мэдлэг, ойлголтыг нотолгоонд суурилан эзэмшинэ.
- ✓ **Зорилтот бүлэг:** ИТХ-ын төлөөлөгчид
- ✓ **Агуулга:** Жендэрийн тэгш байдлын үндсэн ойлголт, онол, хандлага

Сэдэв 1. Жендэрийн мэдрэмжтэй арга барилын хэрэгцээ, ач холбогдол

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Жендэрийн тэгш байдлын үндсэн ойлголт, онол, хандлага. Жендэрийн хэмжүүр, хөгжлийн үзүүлэлтүүд. Тогтвортой хөгжлийн зорилтууд ба жендэрийн төлөв байдал. Жендэрийн тэгш бус байдал, учир шалтгаан, хүчин зүйлс ба үр дагавар. Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих үндэсний тогтолцоо, эрх зүй, бодлогын орчин. Олон улсын билл болон үндэсний хууль тогтоомжийн гол агуулга, үзэл санаа. Жендэрийн мэдрэмжтэй арга барилын онцлог.

Сэдэв 2. Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны цогц стратегийн тухай ойлголт

Ногдох цаг: 2 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны цогц стратегийн тухай ойлголт, ач холбогдол, хэрэгцээ шаардлага

Сэдэв 3. Төлөвлөлт, төсөвлөлт, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн үе шатанд жендэрийн мэдрэмжтэй арга хэрэгсэл ашиглах арга зүй

Ногдох цаг: 4 цаг

Хэлбэр: Лекц, ярилцлага

Сэдвийн агуулга: Төлөвлөлт, төсөвлөлт, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн үе шатанд жендэрийн мэдрэмжтэй арга хэрэгсэл ашиглах арга зүй.

Жендэрийн мэдрэмжтэй оролцоот төлөвлөлтийн арга хэрэгсэл ашиглах нь, төлөвлөлт хийх алхмууд: 1) бэлтгэл ажил, 2) нөхцөл байдлыг тодорхойлох, жендэрийн дүн шинжилгээ хийх хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, 3) асуудлыг тодорхойлох, 4) шийдлийн боломжит хувилбарыг тодорхойлох.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн тухай ойлголт, ач холбогдол.

Төсвийн орлогыг зарцуулах үе шатанд жендэрийн мэдрэмжтэй хяналт тавих нь.

Гүйцэтгэлийн үнэлгээний үе шатанд жендэрийн мэдрэмжтэй хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх нь. Бодлого, хөтөлбөрт жендэрийн шалгуур үзүүлэлт ашиглан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх алхам.

- ✓ **Сургалтын цаг:** 8 цаг
- ✓ **Сургалтын түвшин:** Суурь
- ✓ **Хичээлийн хэлбэр:** Лекц, мэтгэлцээн, кейс дасгал ажиллах, багаар ажиллах
- ✓ **Хөтөлбөр хоорондын уялдаа, холбоо:**

Орон нутгийн бодлого боловсруулалт, төлөвлөлт, Орон нутгийн нийгмийн салбарын бодлого, удирдлага, Орон нутгийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, Орон нутгийн төсөв төлөвлөх, гүйцэтгэлийг хянах арга зүй, Нийгмийн эгэх хариуцлага, Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт, Жендэрийн эрх тэгш байдал